БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.БАТ-ЭРДЭНЭ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын 2 дугаар цэцэрлэгийн их засварын ажил:

Тус барилга нь Дорноговь аймгийн, Сайншанд сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт байрлах ба одоо ашиглагдаж буй 16.51х35.85м-ийн хэмжээтэй, буто чулуун шугаман суурьтай, чулуун ханатай (гадна даацын ханын зузаан 900мм, дотор даацын ханын зузаан 700мм), модон хучилттай, шувуун нуруун дээвэртэй, 2 давхар цэцэрлэгийн зориулалтай болно.

А. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

Б. Цэцэрлэгийн барилгын засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНбД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулж ирүүлэх

Г. Үнийн саналд төсөвт өртгийн дүн **44 000 000** төгрөгийг тусган ирүүлэх ба "Барилгын төсөв зохиох дүрэм" БНбД 81-95-12*(2020)-г мөрдлөг болгоно.

1. Суурийн хүчитгэлийн ажил

Одоо байгаа барилгын суурийн ханын гадна дотор талуудыг сөөлжлөн ухаж хөрсний чийгийг гадагшлуулах шаардлагатай. Механизмаар ухах тохиолдолд суурь суух төслийн төвшингөөс дээш 20-30 см-аар дутуу ухаж, түүнээс доош төслийн түвшин хүртэл гараар ухах хэрэгтэй. Нухний өргөнийг 1 метрээс илүүгүй, нүх тус бүр хоорондоо зурагт заасан хэмжээгээр зайтай байхаар суурийн дэрлэх цутгамал төмөр бетон бүсний өндрийн хэмжээгээр хөдөлмөр хамгаалал аюулгүй байдлыг ханган ажиллаж ухалтын ажлыг гүйцэтгэгэвэл зохино.

Чулуун өргийн барьцалдуулагч зуурмагийн чанар муудсан тул нуралтаас хамгаалах зорилгоор тулаас бэхэлгээг заавал хийх шаардлагатай. Одоо байгаа буурь хөрсийг чийгтэй дээр нь технологийн дагуу сайтар нягтруулалт хүчитгэлийн ажлыг гүйцэтгэх шаардлагатай.

Суурийн хүчитгэлийг ББ-4-6-р хуудсанд заасны дагуу гүйцэтгэвэл зохино. Барилгад X1; X6; Y1; Y2; Y5 тэнхлэг дагууд цутгамал төмөрбетон бүс төлөвлөв.

Бетоны марк М150. Цутгамал төмөр бетон бүсийг хэв хашмалд цутгаж, бетоны бэхжилтийн 70%-г авсаны дараа хэв хашмалыг суллана. Ажлын болон хөндлөн арматурын анги А400, А240 байна. Суурийг буцааж чигжихдээ овойлт үүсгэхгүй хуурай хөрс хэрэглэнэ.

Барилгын суурийг хүчитгэх ажлыг гүйцэтгэхдээ одоо байгаа суурийн доод түвшин хүртэл 1 метр өргөн, нийлэх хэсгийн уртаар хүнхээлийг ухна. Чулуун өргийн

барьцалдуулагч зуурмагийн чанар муудсан тул нуралтаас хамгаалах зорилгоор тулаас бэхэлгээг хийх шаардлагатай.

Хуучин суурийн доод түвшнээс шинээр төлөвлөх суурь хүртэлх газрын ухалт болон бетоны ажлыг гүйцэтгэхдээ тоон заалтын дэс дараалал хэмжээгээр ухна.

Цутгамал төмөр бетон бүсийг цутгаж дуусаад дараагийн хүнхээлийг ухахын өмнө эхний хүнхээлийн нүхийг хуурай элс хайрган хөрсөөр буцаан булалт хийж технологийн дагуу нягтруулалтын ажлыг гүйцэтгэнэ.

Цутгамал төмөр бетон суурийг 1-р ээлжийн 3-н суурийг цутгахдаа 2-р ээлжийн суурь хийх хэсгийн хөрсийг ухаж болохгүй. Цутгамал төмөр бетон суурь 1-р ээлжийн цутгалт дуусаж бэхжилт 50%-д хүрсэний дараа 2-р Ээлжийн суурь цутгах буурь хөрсийг хуулна. Мөн гаднаас ус чийг оруулахгүй байх арга хэмжээг зайлшгүй авсан байх шаардлагатай. Эхний хүнхээлийг технологийн дагуу нягтруулалт хийж булсаны дараа 2 дах хүнхээлийг нээнэ.

Суурийн хүчитгэлийн ажлыг дуусаны дараа гадна болон дотор хануудад гарсан ил болон нэвт ан цавуудад өндөр бат бэхтэй түргэн бэхэждэг шингэн зуурмаг даралтаар шахаж гүйцэтгэнэ.

Мөн хойд талд байрлах дулааны худгийн шугамын усны алдагдлыг бүрэн зогсоож хойд талаар шороо овоолох, эрэг үүсгэх зэргээр гадаргуугийн усыг барилгын цоколоос холуур гаргах шаардлагатай. Суурийн хүчитгэлийн ажлыг эхлэхийн өмнө гүйцэтгэгч байгууллага суурийн хүчитгэлийн ажлын технологийн зураг төслийг гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Хүчитгэлийн ажлыг гүйцэтгэхдээ гүйцэтгэгч нь дараах норм, стандартуудыг баримтлан гүйцэтгэвэл зохино. Үүнд:

"Ачаа ба үйлчлэл" БНБД 20-04-17, "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНбД 22-01-21, "Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм" БНБД 50-01-16, "Ган бүтээц" БНБД 53-03-07, "Бетон ба төмөр бетон бүтээц ерөнхий журам" БНБД 52-01-10, "Цутгамал бетон, төмөр бетон бүтээц" БНБД 52-02-05, "Ган бүтээц" БНЂД 53-02-05, "Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах төлөвлөлт" БНБД 20-02-11, "Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал" БД-22-105-18 г.м

2. Ханын хүчитгэлийн ажил

Одоо байгаа барилгын гадна ханын дээд хэсэг ББ зурагт заасан түвшинд металл швеллер төмрөөр барилыг бүслэж гадна ханыг хүчитгэнэ.

Дотор ханын мөөгөнцөрдсөн гадаргууг стандартын дагуу засварлах, цаашид дотор заслын ажлыг бүрэн сэргээн засварлах, давхар дундын хучилт модон нуруу чийгтэй хэсгүүдийг бүрэн хатаах болон дранктай шавардлагыг засаж сайжруулна.

Гадна хананд дулаалгын үе болон өнгөлгөөг БА зурагт зааснаар хийж гүйцэтгэх.

Суурийн хүчитгэлийн ажлыг дуусаны дараа гадна болон дотор хануудад гарсан ил болон нэвт ан цавуудад өндөр бат бэхтэй түргэн бэхэждэг шингэн зуурмаг даралтаар шахаж гүйцэтгэнэ.

Мөн давхар дундын хучилтын хөшүүнийг нэмэх зорилгоор 1-р давхрын хучилтын хийцлэлд нэмэж налуу банз хадах, 2-р давхрын хучилтад барилгын +7.72 түвшинд 66-16-р хуудсанд заасны дагуу хүчилтгэлийн арга хэмжээг авч гүйцэтгэх.

3. Буулгах ажил

Цэцэрлэгийн барилгын одоо байгаа хана таазны будаг эмульс, хөндийрч муудсан шавардлага, ариун цэврийн өрөөний дүүжин тааз, будагтай ханын гадаргуу, шалны плита, банзан шал, хаалга, цонх, дотор гэрэлтүүлгийн утас, тоноглол, шувуун нуруун дээврийн доторх дулаалга зэргийг буулгаж дараагийн шатны засвар шинэчлэлтийн ажилд бэлдэнэ.

Буулгалтаас гарсан цаашид ашиглах боломжтой материалыг цэцэрлэгийн удирдлагуудад актаар хүлээлгэн өгнө. Буулгалтын ажлын явцад барилгаас гарсан хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт асгана.

Буулгалтын ажил гүйцэтгэх үед хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана.

4. Дотор заслалын ажил

Барилгын дотор заслалын ажлыг гүйцэтгэхдээ БНбД 31-10-05-г мөрдөнө.

Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

Хана, таазны гадаргуугийн хуучин эмульс будгийг сайтар хусч цэвэрлэн гадаргууг бэлэн болсны дараа шинээр хийгдэх заслын ажлыг технологийн дагуу гүйцэтгэнэ.

Ханын гүн хагарсан хэсгүүдийг марк өндөртэй шингэн зуурмагаар шприцээр шуршиж хагарсан ханын ан цавыг битүүлэж, муудаж ховхорсон шавардлагыг буулгаж тортой шавардлага хийнэ.

Дотор ханын гадаргууд тэгшилгээ шавардлага хийхдээ одоо байгаа хананы муруй хазгайг тэгшилж, амалгааг жигд хийнэ. Коридор, ангиудын ханыг шалнаас дээш h=2,0 метрийн түвшинд өнгийн усан суурьтай будгаар 2 үе будна. Заслалын ажил хэрэглэх эко будаг хэрэглэх ба бага насны хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй, үнэргүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн лабораторийн шинжилгээнд хамрагдсан байвал зохино. Будгаас дээш тааз хүртэлх хэсгийн ханыг сайн чанарын эмульсэн будгаар 2 үе чанартай будна. Таазанд гипсэн хавтангаар уналттай тааз угсарч, замаскаар тэгшилгээ хийж, сайн чанарын эмульсэн будгаар будна.

Одоо байгаа ариун цэврийн өрөө, угаалгын өрөө, гал тогооны ханын плитаг хуулж цэвэрлэн тэгшилгээ хийнэ. Шинээр цагаан өнгийн плита нааж уулзварт усны хамгаалалттай чигжээс хийнэ.

Ариун цэврийн өрөөний таазанд метал лампиран хавтан өнгөлгөө хийж, хананд плита наана. Ханын плита наасан хэсгээс тааз хүртэл түвшинд ханыг ус чийгэнд тэсвэртэй эмульсэн будгаар будна.

Гал тогоо, ариун цэврийн өрөө, угаалгын өрөөний таазанд метал лампиран хавтан өнгөлгөө хийнэ.

Ариун цэврийн өрөөнд тусгаарлах ханыг өнгөт хавтангаар хийнэ.

Өрөө тасалгааны өнгөний сонголтыг хийхдээ захиалагч, ашиглагч, зураг төсөл зохиогч байгууллагатай харилцан зөвшилцөх шаардлагатай.

Дотор заслалын ажилд хэрэглэх бүх материалыг сонгохдоо гарал үүслийн бичиг, сертифкаттай, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй эрүүл мэндийн байгууллагаас нотлогдсон бүтээгдэхүүнийг авч ашиглах шаардлагатай.

5. Шалны ажил

Шалны ажилд БНБД 31-09-05 мөрдлөг болгоно.

1-р давхрын шалыг бүхэлд нь хуулж доод хөрсний чийгийг бүрэн гадагшлуулсаны дараа, овойлтгүй хөрс шороо хийж үечлэн нягтруулна. Бетон бэлтгэл БМ100 байна.

Бетон бэлтгэл бүрэн бэхжилтээ авсны дараа шалны угсралтын ажлыг гүйцэтгэнэ. Бүх өрөө тасалгааны шал нь нэг түвшинд байна. Шалны бетон бэлтгэл хийхийн өмнө шалны +-0,00 түвшинг тодорхойлж хэмжээ тавьсан байна. Шалны бетонд хэрэглэгдэх дүүргэгч материал элс, хайргыг орон нутгийн лабораторт шинжлүүлэх нь зүйтэй.

Шалны төрлийг ажлын зурагт заасан тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Цэцэрлэгийн барилгад ашиглах паркет, хулдаас, плитан шал нь эдэлгээ даахуйц сайн чанартай, нян бактер үрждэггүй, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх элмент агуулаагүй, халтирч гулгахгүй гадаргуутай, стандартын шаардлага хангасан, байх шаардлагатайг сайтар анхаарах.

Инженерийн шугам сүлжээ явж байгаа хэсгүүдэд засвар үйлчилгээ хийхэд саадгүй байх нөхцлөөр шалыг хийж өгнө.

6. Хаалга, цонхны ажил

Барилгын хаалга цонхыг угсрахдаа БНбД 25-01-20-ийн шардлагыг хангасан байна.

Цонх хаалгыг захиалахдаа төслийн байранд дахин хэмжилт хийж ажлын зурагт заасан загварын дагуу үйлдвэрт захиалга өгч угсарна.

Бүх цонхыг буулгаж, шинээр сольж суулгахдаа шүүдрийн цэгийг өнгөрөөж буюу ханын зузааны 3/4 дээр, гадна талаасаа ижил 20 см зайд суулгах, цонхыг 2 янзаар онгойлттай /дээшээ хажуу тийш/ байдлаар төлөвлөв. Мөн цонхны тавцанг шинээр суулгана.

Цонхыг тохирлын гэрчилгээтэй эрх бүхий байгууллагад захиалж хийлгүүлэх ба шинээр угсрах цонх нь металл зүрхэвчтэй, хуванцар рамтай 2 давхар шилэн багц бүхий 70 мм-с багагүй зузаантай, цагаан өнгийн рамтай, байх бөгөөд салхи шорооноос хамгаалсан резин хамгаалалт нь стандарт шаардлагыг хангасан байна.

Цонхны резин жийргэвч нь ISO 9001 стандартын шаардлагыг хангасан байна.

Цонхны нугас түгжээ нь бат бөх, ашиглалтын шаардлагыг хангасан 2d болон 3d тохируулгатай байна. Бариул нь 150Н*М-ээс багагүй мушгих моментийн хүчийг 500Н-аас багагүй ачааллыг даах бөх бат чанарыг агуулсан байна.

Резин жийрэг нь цельсийн 500 хэмд хөлдөхгүй, цаг уурын халуун хүйтний өөрчлөлтийг даах чадвартай, эсэлдэж хагарч, хугардаггүй, хөлддөггүй, байгаль орчинд нөлөөгүй, зөөлөн EPDM резин нь стандартын нөхцлийг хангана.

Цонхны загвар хэмжээ, марк, түүврийг зургаас харна.

Ангуудын хаалга PVC самбартай, шилтэй, модон хүрээтэй, бусад өрөө тасалгааны хаалга нь битүү самбартай.

Хаалга, цонхыг төслийн байранд угсарч, бэхэлгээ, чигжээсийг хийж хөдөлгөөнгүй болсны дараа цементэн зуурмагаар гадна дотор талаас нь амалгаа хийнэ. Амалгааны шавардлага нь цонх хаалганы хүрээг 10-20 мм дарсан байна.

Цонхны тавцанг угсрахын өмнө цементэн зуурмагаар тэгшилгээ шавардлага хийж бат бэхийг хангуулсан байна. Хуванцар тавцанг цонхны амалгаанд 20-30 мм суулгаж, дотор талруу нь засал хийсэн хананаас 30-50мм өнгийлттэй байна

Металл рамтай шилэн хана, хаалгыг угсарахын өмнө төслийн байранд дахин хэмжилт хийвэл зохиолтой. Металл рамыг хана, шал, даацын ялуунд тэлэгч боолтоор тал бүрд 1200 мм-с ихгүй алхамтай бэхлэх. Хаалга босогогүй байна. Ханын шил хатжуулсан байх ба хаалганы доод түвшинд хуулгатай байна. Хаалганы онгойлт ба баруун зүүн гарыг ажлын зурагт заасан дагуу гүйцэтгэх. Шилэн ханын рамыг барилгын хана, таазнаас 0.3-0.5 см-н зайтай байхаар угсарч, шахдаг хөөсөөр чигжиж битүүмжлэнэ. Шилэн ханын өнгө барилгын хана, шал, дотор заслалын өнгөтэй ойролцоо байна.

Гадна хананд гэгээвчтэй металл хаалга 2ш, гол орцонд гэгээвчтэй модон хаалга суулгана. Гадна хаалганы уулзварын дулаалгыг сайн чанарын зориулалтын хөөс шахаж хийнэ.

Шинээр угсрах хаалга цонхнууд нь хүүхдийн байгууллагын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахуйц чанартай материалиар хийгдсэн байх ба угсрахдаа хананы зай завсрыг шингэн хөөсөөр сайтар чигжиж өгөх, хаалганы хүрээг хананд сайн тогтоож өгнө.

Хаалга, цонх нь Монгол улсын болон үйлдвэрлэгч улсын чанарын шаардлагыг хангасан ус, чийг, салхины элэгдэлийг даах чадвартай, галд тэсвэртэй, цаг уурын нөхцлөөс шалтгаалан физик, химийн шинж чанараа алдаагүй байх ёстой. Мөн гарал үүслийн гэрчилгээ, чанарын сертификат, үйлдвэрийн албан ёсны хаяг, шошготой байвал зохино.

Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, шавардлагын ажлыг хийсний дараа эмульсэн будгаар будна. Энэ ажилд MNS6266:2011 стандартыг мөрдлөг болгон ашиглана.

Цонхонд усны хаялага төмрийг чанартай материал ашиглан гүйцэтгэнэ.

Барилгын бетон хаяавчийн газрыг тэгшилж сул шороог доргиураар нягтруулж өгнө. Хаяавчийг БМ-100 маркын бетоноор цутгах бөгөөд зураг төслийн дагуу чанартай сайн гүйцэтгэнэ.

Барилгын гадна довжоо болон дотор шатанд төмөр хайс хашлагыг шинэчлэж, тосон будгаар будна. Аваарын төмөр шат, хайс, хашлагыг будна.

7. Дотор гэрэлтүүлэг, галын дохиоллын ажил

Дотор гэрэлтүүлгийн ажлыг гүйцэтгэх үед БД43-101-03 “Цахилгаан байгууламжийн дүрэм”, “Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг” БНбД 23-02-08 БНбД 21-01-02 “Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал” -г мөрдлөг болгоно.

Гэрэлтүүлэг:

Ажлын гэрэлтүүлгийн сүлжээний хүчдэл 220В байна. Гэрэлтүүлэгчдийг өрөөний зориулалт, архитектурын шийдэл, технологийн байгуулалтыг үндэслэн сонгов. Техникийн өрөөнүүд, ариун цэврийн өрөөнүүдэд ус чийгнээс хамгаалагдсан

(IP-54-с дээш) гэрэлтүүлэгч, анги болон бусад өрөөнүүдэд таазанд моноглох эрчим хүчний хэмнэлттэй LED (IP-20-с дээш) гэрэлтүүлэгч суурилуулна.

Тоног төхөөрөмжийг угсрах

Гэрэлтүүлгийн самбар шалнаас +1.5м-н өндөрт, ангийн розетка +1.8м-н өндөрт, бусад өрөөний розетка +0.4м-н ендерм, ариун цэврийн өрөөний розеткыг +1.2м-н өндөрт тус тус байрлуулах шаардлагатай. Ангид залгуурыг сугалахад үүрийг нь хаадаг хамгаалах тоноглолтой розеткыг байрлуулна. Барилгын хүчит мехееремж, гэрэлтүүлэг, розеткын шугаманд ПВ-660 маягийн зэс голтой утасыг ханаар, таазаар, шалны бэлтгэлээр пластмассан хоолойд сүвлэж далд тоноглоно. ПВ-660 кабель нь шаталтыг дэмждэггүй, утаа ба хий ялгаруулдаггүй болно. Розеткыг холбохдоо заавал холболтын хайрцагтай хийнэ.

Галын дохиоллын системийг холбогдох норм дүрэм, ажлын зурагт тусгасны дагуу угсарч суурилуулна.

8. Гал тогооны салхивчийн ажил

Дотор халаалт, агаар сэлгэлтийн системийг угсрахдаа БНБД 40-06-15-ийг баримтанлна

Агаар сэлгэлтийн системийн хоолой нь тэгш өнцөгт хэлбэртэй цайрдсан /галд тэсвэртэй Е30-60/ хоолой байна. Агаар сэлгэлтийн ситемийн дамжуулах хоолой, хийц эдлэхүүн батлагдсан зураг төслийн дагуу хийгдсэн байх шааодлагатай. Агаар дамжуулах тэгш өнцөгт огтлолтой хоолойн их талын хэмжээс нь 250мм хүртэл үед 0.5мм, 300-1000мм үед 0.7мм-ээс багагүй зузаантай ган хуудас сонгоно.

Тэгш өнцөгт огтлолтой дамжуулах хоолойн аль нэг тал 800мм хүртэл үед хөшүүн байдлыг хангах зорилгоор хоолойн хананд 200-300мм тутамд ховил эсвэл нугалаа гаргана. Хоолойн эсрэг талуудыг 400мм тутамд боолтоор чагталж бэхлэх шаардлагатай. Дамжуулах хоолой, холбох хэрэгслийг нугалах, эмхэрдэх, гагнах, тавлаж хадах аргаар холбоно. Хэт чийглэг агаар болон тэсрэх аюултай тоос дамжуулах хоолойг эмхэрдэх, нугалах аргаар холбохыг хоргилоно. Тэгш өнцөгт хоолойг фланецаар холбосны дараа холболт бат бэх, нягт байх шаардлагатай. Агаар дамжуулах хоолойд фланецыг суулгахдаа хоолойн ирмэгийг бортголон нугалж гагнуур, цэгэн гагнуураар эсвэл 4-5 мм голчтой хадаас, шурган хадаасаар (ширхэглэг хольц агуулаагүй агаар дамжуулж буй үед) 200-250мм зайтайгаар дөрвөөс доошгүй удаа хадаж бэхлэх шаардлагатай. Агаарын урсгал тохируулах хаалт, хавхлага, тохируулгатай агаар хуваарилагч болон бусад хийцүүд чөлөөтэй нээгдэж хаагддаг, шаардлагат тохируулгыг хийх боломжтой байх ёстой.

9. Гадна фасад, дээврийн дулаалгын ажил

Барилгын үндсэн хананд 50 мм зузаантай хавтгаалжин шилэн хөвөн дулаалгыг 2 үе хийнэ. Шилэн хөвөнгийн дулаан дамжуулах чанар R=3,0 м^2 ОС/ВТ –аас багагүй байна. Дулаалга хийхийн өмнө бэхэлгээний деталл буюу кроштэйнийг ажлын зурагт заасан зай хэмжээний дагуу бэхэлсэн байна. Эхний 1-р үеийн шилэн хөвөн хавтгаалжийг хананд цавуут зуурмагаар нааж байрлуулсны дараа зам төмөр буюу профилийг урьдчилсан байрлуулсан бэхэлгээний деталлд бэхлэнэ. Үүний дараа 2-

р үеийн шилэн хөвөн хавтгаалжийг дюбелийн тусламжтай бэхлэнэ. Дулаалга хийсэн хананд ажлын зурагт заасан өнгийн металл хавтанг угсарна.

Бетон хаяавч цутгах БМ100 маркийн бетоноор 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх.

Одоо байгаа шувуун нуруун дээвэр доторх хуйлмал материалыг хуулж буулган, 1 үе ус тусгаарлагч дэвсэн, 150 мм-ийн шилэн хөвөн хавтангаар дулаалж өгнө.

Барилгын хүчитгэл засварын ажилд мөрдөж ажиллах БНбД, стандартууд
Гэрээт ажлыг гүйцэтгэхэд мөрдөж ажиллах Монгол улсын барилгын норм, дүрмүүд БНбД ба стандартууд:

	Норм, дүрмийн нэр	Дугаар
1-р хэсэг. Барилгын үйлдвэрлэл, ажил гүйцэтгэх ба хүлээн авах		
1.1	Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт	БНбД 12-01-09
1.2	Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх ашиглалтад оруулах дүрэм	ЗГ-ын 2021 оны 212, 213 дугаар тогтоол
1.3	"Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм"	БНбД 12-02-24
2-р хэсэг. Барилгын бүтээц		
2.1	Ачаалал ба үйлчлэл	БНбД 20-04-17
2.2	Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал	БНбД 21-01-02
2.3	Барилгын дулаан хамгаалалт	БНбД 25-01-20
2.4	Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм	БНбД 22.01.01*/2006
2.5	Ган бүтээц (Зураг төсөл боловсруулах норм ба дүрэм)	БНбД 53-03-07
2.6	Барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах	БНбД 20-02-11
2.7	Барилга, байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл	БНбД 21-04- 05*/18
3-р хэсэг. Тусгаарлалт, хамгаалалтын түрхлэг, заслын ажил		
3.1	Дээврийн ажил	БНбД 31-07-05
3.2	Заслын ажил	БНбД 31-10-05
3.3	Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах	БНбД 20-02-11
3.4	Шалны ажил	БНбД 31-09-05
4-р хэсэг. Цахилгааны ажил		
4.1	Цахилгаан байгууламжийн дүрэм	БД 43-101-03
4.2	Цахилгаан техникийн ажил	БНбД 3.05.06-90

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилга байгууламжийн угсралтын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНбД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилга угсралт, засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
7. Барилга байгууламжийн угсралтын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
9. Хэрэв материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.
11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
12. Монгол Улсын "Барилгын тухай" хуулийн 14.3–т */барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/* 14.4-т */14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/* 14.5-д */14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/* 14.6-д */14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа 3-аас доошгүй жил байна/* гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.

Хуулиар тогтоосон чанарын баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал гүйцэтгэгч компани нь

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.9.2-д заасны дагуу үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлаж, ашиглалтын хэвийн байдалд оруулах үүрэг хүлээнэ.

ХЯНАСАН:

ГХБХБГ-ЫН ДАРГА Л.ОЛЗБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА Ц.БАЯРМАА